

**Захиалагчийг төлөөлж:**

Түшиг сумын Засаг дарга

/Г.Батболд/

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**

Ачлалт төмөр хэлхээ ХХК-ний захирал

Л.Ган-Очир/

**ТҮШИГ СУМЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ  
(Өнгөлөг гудамж) АЖЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2024.04.25

№СЭТУ-ХА-2024-07

Түшиг сум

Нэг талаас Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Засаг дарга Гомбодорж овогтой Батболд /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас "Ачлалт төмөр хэлхээ" ХХК-ний захирал Пулемёт овогтой Ган-Очир /цаашид гүйцэтгэгч гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү "НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ АЖИЛ (Өнгөлөг гудамж)"-ын ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд "**НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ АЖИЛ (Өнгөлөг гудамж)**"-ын хүрээнд нэр төрөл бүхий бараа материалыг нийлүүлэх, захиалагч гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь 2024 онд 120,886,588 (зуун хорин сая найман зуун наян зургаан мянга таван зуун наян найм) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

**Санхүүжилтийн хуваарь:**

- Гэрээний нийт дүн 120,886,588 төгрөг бөгөөд гэрээний үнэд дараах зардлууд багтсан болно. Үүнд:

- Техник хяналтын зардал 1,960,177 төгрөг
- Зураг төсвийн үнэ 8,000,000 төгрөг
- Зохиогчийн хяналтын зардал 980,088 төгрөг
- Магадлашгүй ажлын зардал 1,960,177 төгрөг

Ажлын үе шатны хуваарийн дагуу 40% буюу 48,346,635 төгрөгийг 2024 оны 05 дугаар сарын 20нд

Ажлын 60%-ийн гүйцэтгэлээр хийгдсэнээр санхүүжилтийн 40% буюу 48,346,635 төгрөгийг 2024 оны 06 дугаар сарын 10нд

-Ажлыг бүрэн хүлээлгэж өгсөнөөр үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

3.Гүйцэтгэгч нь “НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ АЖИЛ (ӨНГӨЛӨГ ГУДАМЖ)”-ыг 2024 оны 06 дугаар сарын 30-ны дотор технологит хугацаанд бүрэн гүйцэтгэж дуусна.

4.Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. /Цаашид гэрээний баримт бичиг гэх/

Үүнд:

- Гэрээ байгуулах тухай хүсэлт
- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5.Захиалагч гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хариуцлагыг хүлээнэ.

6.Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцуулэн гэрээнд ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7.Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

8.Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.



Захиалагчийг төлөөлж:

Тушиг сумын Засаг дарга

/Г.Батболд/

Сэлэнгэ аймгийн Тушиг сумын ЗДТГазар

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Ачлалт төмөр хэлхээ ХХК-ний захирал



/П.Ган-Очир/

Утас: 99147988